

БАТЛАВ  
УС СУВГИЙН УДИРДАХ ГАЗРЫН ДАРГА



Т.ВАНДАНДОРЖ

УЛААНБААТАР ХОТЫН  
УС СУВГИЙН УДИРДАХ ГАЗАР ОНӨААТҮГ

## ҮЙЛЧИЛГЭЭ АВАХ ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН БАРИМТ БИЧИГ

Тендер  
шалгаруулалтын  
нэр:

*Зураг, төсөв хийх үйлчилгээ үзүүлэх.*

Тендер  
шалгаруулалтын  
дугаар:

УСУГ/20240103030

# I БҮЛЭГ.ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА

## А.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

### 1. Тендерийн цар хүрээ

1.1.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “Хууль” гэх)-ийн дагуу өгөгдлийн хүснэгтэд заасан захиалагч III бүлэгт тодорхойлсон үйлчилгээ (цаашид “үйлчилгээ” гэх) худалдан авахаар тендер шалгаруулалтыг зохион байгуулна. Тендер шалгаруулалтын нэр болон дугаарыг өгөгдлийн хүснэгтэд заана.

1.2.Тендер шалгаруулалт багцтай бол энэ тухай мэдээллийг өгөгдлийн хүснэгтэд заана.

1.3.Хуулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа үед энэ тухай өгөгдлийн хүснэгтэд заана.

### 2. Санхүүжилтийн эх үүсвэр болон төсөвт өртөг

2.1.Тендер шалгаруулалтын нийт болон багц тус бүрийн санхүүжилтийн эх үүсвэр, батлагдсан төсөвт өртгийг өгөгдлийн хүснэгтэд тусгана.

### 3. Худалдан авах ажиллагааны хууль тогтоомж

3.1.Энэ худалдан авах ажиллагаанд хуулийн 2.1-д заасан төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.

### 4. Худалдан авах ажиллагааны цахим систем

4.1.Тендер шалгаруулалтыг Сангийн сайдын баталсан “Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам”-ын дагуу худалдан авах ажиллагааны цахим систем ([www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn)) /цаашид “цахим систем” гэх/-ээр зохион байгуулна.

### 5. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх

5.1.Захиалагч, сонирхогч этгээд, оролцогч болон хуулийн 52.1-д заасан ажилтан, албан тушаалтан Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль, Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуулиар хориглосон үйлдэл, эс үйлдлийн талаар холбогдох албан тушаалтан, хууль хяналтын байгууллагад хууль тогтоомжийн дагуу мэдэгдэнэ.

5.2.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20, 20<sup>1</sup>, 21 дүгээр зүйлд заасан хориглолт, хязгаарлалтад хамаарах этгээд тендер шалгаруулалтад оролцох эрхгүй байна.

### 6. Сонирхогч этгээд, оролцогчид тавигдах ерөнхий шаардлага

6.1.Аж ахуй эрхлэгч нь хуулийн 22.10-т зааснаар үйлчилгээний хураамж төлснөөр тус тендер шалгаруулалтын сонирхогч этгээд болно.

6.2.Сонирхогч этгээдийн төлсөн үйлчилгээний хураамжийг аливаа үндэслэлээр буцаан олгохгүй.

6.3.Оролцогчтой холбоотойгоор хуулийн 7.1-д заасан нөхцөл үүсээгүй буюу ерөнхий шаардлагыг хангасан

байна.

6.4.Оролцогч хуулийн 6 дугаар зүйлд нийцүүлэн тендер ирүүлнэ.

6.5.Тендер шалгаруулалтад оролцох гадаадын этгээд үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу эцсийн өмчлөгчөөр бүртгэгдсэн этгээдийн мэдээллийг ирүүлнэ.

6.6.Монгол Улсын хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд зааснаар бүртгүүлсэн мэдээлэлд үндэслэнэ.

6.7.Монгол Улсын олон улсын гэрээнд үл нийцэх, худалдааны хоригт хамаарах этгээд тендер ирүүлэх эрхгүй.

## **7. Туслан гүйцэтгэгч, түншлэлд тавигдах шаардлага**

7.1.Тендерт ирүүлэх түншлэлийн гэрээ, туслан гүйцэтгүүлэх гэрээ нь хуулийн 6 дугаар зүйлд заасан шаардлага хангасан байна.

7.2.Туслан гүйцэтгүүлэх гэрээ хуулийн 6.4-т заасныг зөрчсөн бол захиалагч тухайн туслан гүйцэтгүүлэх гэрээ, туслан гүйцэтгэгчид холбогдох баримт бичгийг тендер хянан үзэхэд харгалзан үзэхгүй.

7.3.Түншлэлийн болон туслан гүйцэтгэгчийн хувиар оролцохыг зөвшөөрсөн болохыг түншлэлийн гишүүн болон туслан гүйцэтгэгч цахим системээр баталгаажуулсан байна.

7.4.ТШЗ-ны 7.3-т заасан нь гадаадын этгээд түншлэлийн гишүүн, эсхүл туслан гүйцэтгэгчээр ороход хамаарахгүй.

7.5.Түншлэлийн гишүүн, туслан гүйцэтгэгч тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэгдсэн хугацаа дуусгавар болоогүй бол ерөнхий шаардлагад нийцэхгүй гэж үзнэ.

## **Б. АГУУЛГА**

### **8. Тендер шалгаруулалтын баримт бичиг**

8.1.Тендер шалгаруулалтын баримт бичиг нь доор дурдсан бүлэг болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөс бүрдэнэ:

I Бүлэг. Тендер шалгаруулалтын зааварчилгаа;

II Бүлэг. Өгөгдлийн хүснэгт;

III Бүлэг. Техникийн тодорхойлолт, тавигдах шаардлага;

IV Бүлэг. Тендерийн үнэлгээний шалгуур үзүүлэлт;

V Бүлэг. Тендерийн жишиг маягт;

VI Бүлэг. Гэрээний нөхцөл.

8.2.Сонирхогч этгээд ТШЗ, өгөгдлийн хүснэгтэд заасан шаардлага, шалгуур үзүүлэлт, гэрээний нөхцөл, тендерийн жишиг маягт, техникийн тодорхойлолт болон түүнд оруулсан аливаа өөрчлөлт, иш татсан хууль, журам, зааврыг судалж, тэдгээрт нийцүүлэн тендер бэлтгэнэ.

### **9. Тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулах**

9.1.Сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичигт заасан асуудлаар тодруулга авах бол энэ тухай хүсэлтийг тендерийн нээлтээс ажлын таваас доошгүй өдрийн өмнө бичгээр захиалагчид гаргаж болно.

9.2.Тодруулга авах хүсэлтийг өгөгдлийн хүснэгтэд заасан хаягаар хүлээн авна.

9.3.Тодруулга авах хүсэлтэд үйлчилгээний хураамж төлсөн баримтыг хавсаргана.

9.4.Захиалагч тодруулга авах хүсэлтийн хариуг албан бичгээр үйлдэж, цахим системд нийтэлснээр хүргүүлсэн гэж тооцно.

9.5.Захиалагч тодруулгын үр дүнд тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл ТШЗ-ы 11-д заасныг мөрдөнө.

#### **10. Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт**

10.1. Хуулийн 19.4-т зааснаар уулзалт зохион байгуулах, эсхүл ажлын талбайтай танилцуулах бол Өгөгдлийн хүснэгтэд заана.

10.2. Уулзалтад сонирхогч этгээд, түүний төлөөлөл оролцоно.

10.3. ТШЗ-ны 10.1-д заасан уулзалтад оролцоогүй аж ахуй эрхлэгч тендер шалгаруулалт шалгаруулалтад оролцож болно.

#### **11. Тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах**

11.1. Тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө захиалагч тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

11.2. Тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулсан бол түүнийг цахим системд нийтэлснээр хүчинтэйд тооцогдоно.

11.3. Хэрэв тендер нээхээс ажлын таван өдрийн дотор тендер шалгаруулалтын баримт бичигт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг оруулсан бол тендер хүлээн авах эцсийн хугацааг ажлын таваас доошгүй өдөр байхаар тооцож, шаардлагатай хугацаагаар сунгана.

### **V. ТЕНДЕР БЭЛТГЭХ**

#### **12. Тендер шалгаруулалтын баримт бичгийн болон тендерийн хэл**

12.1. Тендер шалгаруулалтын зарлал, баримт бичиг, урилгыг гадаад хэлээр давхар нийтэлсэн эсэхээс үл хамааран тендер шалгаруулалтын баримт бичиг, тендер шалгаруулалттай холбогдох албан бичиг, захидал, бусад баримт бичиг, оролцогчийн ирүүлэх тендер монгол хэлээр байх ба өөр хэлээр үйлдсэн тендер, түүний доторх баримт бичиг, мэдээллийг орчуулсан орчуулгыг тендерт оролцогч бэлтгэн ирүүлнэ.

12.2. Зөвхөн гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх үйлчилгээ авах тендер шалгаруулалтын хувьд Монгол Улсын олон улсын гэрээг үндэслэн хэлийг өгөгдлийн хүснэгтэд өөрөөр зааж болно.

12.3. Хэрэв ТШЗ-ны 12.2-т зааснаар бэлдсэн тохиолдолд тендер шалгаруулалтын баримт бичгийн монгол хэл болон гадаад хэлээр бэлтгэсэн хувилбар хоорондоо зөрвөл монгол хэлээр бэлтгэсэн хувилбарыг баримтална.

12.4. Тендер хянан үзэх, үнэлэхэд захиалагч гадаад хэлээр үйлдсэн баримт бичгийн орчуулгыг үндэслэх ба оролцогч өөрөө, эсхүл бусад этгээд орчуулсан эсэхээс үл хамааран үнэн зөв, зөрүүгүй болохыг захиалагчийн өмнө хариуцна.

### **13. Тендерийн иж бүрдэл**

13.1. Тендер нь хуулийн 21.1-д нийцүүлж бэлтгэсэн үйлчилгээ үзүүлэх техникийн болон үнийн санал байна.

13.2. Оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер дараах баримт бичиг, мэдээллээс бүрдэнэ:

13.2.1.ТШЗ-ны 14-т заасны дагуу бэлтгэсэн маягтууд;

13.2.2.оролцогчийн итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээдээс өөр этгээд тендерийг баталгаажуулсан бол холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн олгосон итгэмжлэл /гадаадын этгээдийн хувьд итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг нотлох баримт/;

13.2.3.ТШЗ-ны 15-д заасны дагуу бэлтгэсэн хувилбарт санал;

13.2.4.оролцогч ТШЗ-ны 16-д заасан ерөнхий шаардлагыг хангасан болохыг нотлох баримт бичиг;

13.2.5.тендерт оролцогчийн чадавх, туршлага ТШЗ-ны 17, 18, 19-д заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангахыг нотлох баримт бичиг;

13.2.6.санал болгож буй үйлчилгээ ТШЗ-ны 20-д заасан шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг;

13.2.7.ТШЗ-ны 21-д заасан үйлчилгээ үзүүлэх төсөв;

13.2.8.ТШЗ-ны 21.5-д заасан тохиолдолд холбогдох тайлбар;

13.2.9.Түншлэлээр, эсхүл туслан гүйцэтгэгчтэй бол холбогдох гэрээ.

13.3.Оролцогч өөрийн тендерийн бүх баримт бичиг, мэдээллийн хүчинтэй байдлыг нягтлах үүрэгтэй бөгөөд үнэн зөвийг захиалагчийн өмнө хариуцна.

13.4.Оролцогч хуулийн 22.7, 22.10-т заасныг үндэслэн тендерийн баталгаа хүргүүлж, үйлчилгээний хураамж төлснөөр тендер илгээнэ.

### **14. Тендерийн жишиг маягтууд**

14.1.Оролцогч V бүлэгт заасан маягтын мэдээллийг хуулийн 21.1.3-т зааснаар цахим системд үүсгэсэн маягтад бөглөж, илгээнэ.

### **15. Хувилбарт санал**

15.1.Өгөгдлийн хүснэгтэд заасан бол хуулийн 11.10-т заасан шаардлагад нийцэх хувилбарт саналыг тендерийн хамт ирүүлж болно.

### **16. Ерөнхий шаардлагыг магадлах баримт бичиг**

16.1.Оролцогчийн ерөнхий шаардлага хангасан эсэхийг дараах баримт бичгээр магадлана. Үүнд:

16.1.1.ТШЗ-ны 14.1-д заасны дагуу бөглөж ирүүлсэн V бүлгийн Маягт 1.

16.1.2.Ерөнхий шаардлагыг хангасан эсэхийг магадлахтай холбоотой ирүүлэх бусад баримт бичгийг хуулийн 7 дугаар зүйлд нийцүүлэн өгөгдлийн хүснэгтэд заана.

16.2.Гадаадын этгээд нь үүсгэн байгуулагдсан, эсхүл

оршин суугаа улсын төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан дараах баримт бичиг, эсхүл түүнтэй адилтгах баримт бичгийг ирүүлнэ:

16.2.1. хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээ, түүнийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг тодорхойлох баримт бичиг;

16.2.2. гадаадын иргэн, харьяалалгүй хүн бол паспорт, түүнийг орлох баримт бичиг;

16.2.3. тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар тухайн улсын хуулиар татварын хугацаа хэтэрсэн өргүй болохыг нотлох баримт бичиг.

16.3. Захиалагч оролцогчийн ерөнхий нөхцөлийг магадлах зорилгоор зөвхөн ТШЗ-ны 16.1, 16.2.2-т заасан баримт бичгээс бусад баримт бичгийг ирүүлэхийг оролцогчоос шаардахгүй ба шаардлагатай бусад нөхцөлийг оролцогчийн ирүүлсэн мэдэгдэл, хуулийн 15.2-т заасан мэдээлэлд үндэслэн магадална.

16.4. Түншлэлийн гишүүн тус бүр ТШЗ-ны 16.1, 16.2-т заасан баримт бичиг ирүүлнэ.

## **17. Чадавхын болон туршлагын шаардлага**

17.1. Захиалагч ТШЗ-ны 18, 19-д заасан чадавхын болон туршлагын шаардлага тогтооход хуулийн 15 дугаар зүйлийг баримтална.

17.2. Хуулийн 15.2-т заасан цахим системээр дамжуулан шалгах боломжтой, олон нийтэд нээлттэй мэдээллийг нотлох баримтаар ирүүлэхгүй.

**17.3.** Түншлэлийн хувьд төлөөлөх эрх бүхий гишүүн, гишүүн хамтдаа ТШЗ-ны 18, 19-д заасан чадавхын болон туршлагын шаардлагыг бүрэн хангасан байна.

17.4. Түншлэлийн төлөөлөх эрх бүхий гишүүн ТШЗ-ны 18, 19-д чадавхын болон туршлагын шаардлагын 40-аас дээш хувийг, түншлэлийн гишүүн тус бүр 25 ба түүнээс дээш хувийг хангасан байна.

17.5. Туслан гүйцэтгэгч нь энэ зүйлд заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийн өөрт холбогдох хэсгийг хангаж байгааг нотлох баримт бичгийг тендерт ирүүлнэ.

## **18. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт**

18.1. Хуулийн 16.5-д зааснаар оролцогч өгөгдлийн хүснэгтэд заасан санхүүгийн чадавхын шаардлага хангасан байна.

18.2. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 16.2, 16.4-т заасан баримт бичгээс сонгож өгөгдлийн хүснэгтэд заана.

18.3. Оролцогчийн дансны мэдээлэл, түүний үлдэгдлийн талаар харилцагч банкны мэдэгдлээс бусад банк, санхүүгийн байгууллагын мэдэгдлийг оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд харгалзан үзэхгүй. Захиалагч энд зааснаас бусад асуудлаар харилцагч банкны тодорхойлолт ирүүлэхийг шаардахгүй.

18.4. Монгол Улсын хуулийн этгээдийн банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх

талаар лавлагааг Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан этгээдээс цахим системээр авч, тендерт ирүүлэх ба уг асуудлаар банк, санхүүгийн байгууллагаас лавлагаа ирүүлэхийг шаардахгүй.

### **19. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт**

19.1. Хуулийн 17.4-т зааснаар оролцогч өгөгдлийн хүснэгтэд заасан техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангасан байна.

19.2. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 17.2.1, 17.2.3, 17.2.4-т заасан баримт бичгээс сонгож өгөгдлийн хүснэгтэд заана.

19.3. Үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай зөвшөөрөл, эсхүл гэрчилгээ байгаа бол өгөгдлийн хүснэгтэд заана.

19.4. ТШЗ-ны 19.3-т заасан тусгай зөвшөөрлийн шаардлагыг түншлэлийн гишүүн тус бүр хангасан байна. Хэд хэдэн зөвшөөрөл, гэрчилгээ шаардсан бол түншлэлийн гишүүд хамтдаа бүрэн хангасан байна.

### **20. Санал болгож буй үйлчилгээ шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг**

20.1. Санал болгож буй үйлчилгээ нь III бүлэгт заасан техникийн тодорхойлолт, тавигдах шаардлагад нийцсэнийг нотлох баримтыг тендерт ирүүлнэ.

20.2. III бүлэгт заасан техникийн тодорхойлолтын аль нэг зүйлээс зөрүүтэй, орхигдуулсан бол энэ тухай тайлбарыг ирүүлнэ.

20.3. Үйлчилгээ үзүүлэхтэй холбоотойгоор тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдээс бараа, үйлчилгээ авахаар санал болгосон бол шаардлагад нийцэхгүй гэж үзнэ.

### **21. Тендерийн үнэ ба үнийн хөнгөлөлт**

21.1. Оролцогчийн санал болгож буй үнэ, үнийн хөнгөлөлт нь энэ зүйлд заасан шаардлагад нийцсэн байна.

21.2. Үнийн задаргаанд тусгайлан тусгасан эсэхээс үл хамааран тендерийн үнэд хуулийн 27.13-т заасан зардлыг багтсанд тооцно.

21.3. Үнийн хөнгөлөлт санал болговол үнийн хөнгөлөлт тооцсоны дараах үнийг “тендерийн үнэ” гэж үзнэ.

21.4. Хууль болон өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол оролцогчийн санал болгосон үнэ нь гэрээний хэрэгжилтийн явцад тогтмол байх бөгөөд тохируулга хийхгүй. Тохируулга хийх нөхцөлтэй үнэ санал болгосон тендерийг шаардлага хангаагүй гэж үзнэ. Өгөгдлийн хүснэгтэд үнийн тохируулга хийхийг зөвшөөрсөн тендер шалгаруулалтад тогтмол үнэ санал болгосон тендер ирүүлсэн нь тендерээс татгалзах үндэслэл болохгүй ба үнийн тохируулга нь гэрээний хэрэгжилтийн явцад тэгтэй тэнцүү гэж үзнэ.

21.5. Хуулийн 21.5-д заасан тохиолдолд тендер шалгаруулалтын оролцогчийн тендерийн үнэ төсөвт өртгийн 80 хувиас доош бол уг үнэ нь үйлчилгээний хамрах хүрээ, чанар болон гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлэхгүй талаар үндэслэл бүхий тайлбарыг тендерт

ирүүлнэ.

## **22. Тендерийн валют**

22.1. Монгол Улсын олон улсын гэрээ болон хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол тендерийн үнийг Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4.1, 4.2-т заасны дагуу үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэхээр заана.

## **23. Тендер хүчинтэй байх хугацаа**

23.1. Оролцогч хуулийн 21.1.1-д заасны дагуу тендер нээснээс хойш өөрийн тендер хүчинтэй байх хугацааг ажлын 30-аас багагүй өдөр байхаар маягт 1-д заана.

23.1. Захиалагч хуулийн 28.8-д зааснаар тендер хүчинтэй байх хугацаа сунгах хүсэлт гаргасан бол оролцогч өөрийн ТШЗ-ны 23.1-д заасан хугацааг сунгаж болно.

23.2. Оролцогч тендерийн хүчинтэй байх хугацааг сунгасан бол ТШЗ-ны 24-т заасан тендерийн баталгааны хүчинтэй байх хугацаа мөн адил тендерийн баталгааны нөхцөлийн дагуу сунгагдахыг баталгаа гаргагч болон оролцогч хариуцна.

23.3. Хуулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж буй тохиолдолд оролцогчийн тендерийн хүчинтэй байх хугацаа нь тухайн ажлын санхүүжилтийн эх үүсвэр батлагдсаны дараа гэрээ байгуулах хүртэл хугацаанд хүчинтэй байхаар заана.

## **24. Тендерийн баталгаа**

24.1. Захиалагч хуулийн 14.1-д заасан тохиолдолд төсөвт өртгийн 0.5 хувиар тооцсон “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-д нийцсэн тендерийн баталгаа ирүүлэхийг өгөгдлийн хүснэгтэд заана.

24.2. Хуулийн 14.6-д зааснаар дараах тохиолдолд тендерийн баталгааг хуульд заасан хувь, хэмжээгээр улсын орлого болгоно. Үүнд:

24.2.1. ТШЗ-ны 23-т заасан тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө өөрийн тендерээс бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн татгалзсан;

24.2.2. гэрээ байгуулах эрх авсан оролцогч гэрээ байгуулах, эсхүл гүйцэтгэлийн баталгаа ирүүлээгүй;

24.2.3. Захиалагчийн шийдвэртэй холбогдуулан Сангийн яаманд гаргасан гомдлыг бүхэлд нь үндэслэлгүй гэж шийдвэрлэсэн.

24.3. Тендер шалгаруулалтыг багцад хуваасан бол тендерийн баталгааг багц тус бүрд ирүүлнэ.

24.4. Түншлэлийн хувьд түүнийг төлөөлөх эрх бүхий гишүүн тендерийн баталгааг ирүүлнэ.

## **Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ**

### **25. Тендер баталгаажуулах, илгээх**

25.1. Тендерийг хуулийн 22.1-д зааснаар баталгаажуулан, тендерийн баталгаа шаардсан тохиолдолд тендерийн баталгааг ТШЗ 24-т зааснаар илгээнэ.

25.2. ТШЗ-ны 25.1-д заасны дагуу баталгаажуулсан этгээд оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд бол итгэмжлэл ирүүлэх шаардлагагүй.

25.3. Оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд тендерийг тоон гарын үсгээр баталгаажуулсан бол



V бүлэгт заасан маягтыг ТШЗ-ны 25.1-д зааснаар тамга, тэмдгээр баталгаажуулсан гэж үзнэ. Энэ тохиолдолд маягтыг баталгаажуулахтай холбоотой итгэмжлэл үйлдэх, хуулийн этгээдийн тамга, тэмдгээр баталгаажуулахыг шаардахгүй.

25.4. Оролцогч хуулийн 22.5-д заасан хүний эмзэг мэдээлэлд хамаарах мэдээллийг ил болгохгүйгээр илгээх бол хуулийн 22.6.3-т заасан мэдэгдлийг V бүлгийн 07-ын дагуу нууцлахгүйгээр ирүүлнэ.

25.5. Хуулийн 22.6-д заасан баримт бичиг, мэдээллийг заавал ил болгож илгээх ба ТШЗ-ны 25.4-т заасан нь тус баримт бичгүүдэд хамаарахгүй. Захиалагч тухайн тендер шалгаруулалтад нэмэлтээр ил болгох баримт бичгийг өгөгдлийн хүснэгтэд заах ба уг баримт бичиг хүний эмзэг мэдээлэл хамаарах бол мэдээллийн эзний зөвшөөрлийг авсны үндсэн дээр тендер илгээнэ.

#### **26. Тендер хүлээн авах эцсийн хугацаа**

26.1. Тендер хүлээн авах эцсийн хугацааг өгөгдлийн хүснэгтэд заана. Огноо, цагийг цахим системийн серверийн цагаар тооцно.

26.2. Захиалагч тендерийн нээлтийг цахим системээр өгөгдлийн хүснэгтэд заасан огноо, цагт зохион байгуулна. Тендерийн нээлтэд оролцогч, эсхүл түүний төлөөлөгч байлцах эрхтэй.

### **Д. ЗАХИАЛАГЧ ШИЙДВЭР ГАРГАХ**

#### **27. Тендерийн талаар тодруулга авах**

27.1. Захиалагч тендерийн талаар тодруулга авах тохиолдолд хуулийн 25 дугаар зүйлд заасан журмыг баримтална.

#### **28. Тендерийг шаардлагад нийцсэн эсэхийг хянан үзэх**

28.1. Тендерийг хянан үзэхэд хуулийн 26 дугаар зүйлд заасан журам, ТШЗ-ны 13-т заасан тендерийн иж бүрдэл, холбогдох мэдээллийн сангаас илгээсэн мэдээлэл, оролцогч болон түүний тендерийн талаар авсан тайлбар, тодруулгад үндэслэн хянан үзнэ.

#### **29. Тендерийг үнэлэх**

29.1. Захиалагч тендерийг хуулийн 27 дугаар зүйл, Сангийн сайдын “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-ын дагуу үнэлж, харьцуулна.

#### **30. Арифметик алдааг залруулах**

30.1. Тендерийн үнийн арифметик алдааг “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-т зааснаар залруулна.

30.2. ТШЗ-ны 30.1-д заасны дагуу арифметик алдааг залруулсан тухай мэдээллийг оролцогчид хүргүүлнэ.

#### **31. Үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт**

31.1. Өгөгдлийн хүснэгтэд заасан бол IV бүлэгт заасан үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг мөнгөөр илэрхийлж, харьцуулах үнийг хийсвэрээр нэмэгдүүлнэ.

#### **32. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлох**

32.1. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлоход дараах дарааллыг баримтална:

32.1.1. ТШЗ-ны 21.1-д зааснаар санал болгосон тендерийн үнийг тогтоох;

32.1.2. ТШЗ-ны 21.3-д заасны дагуу санал болгосон

үнийн хөнгөлөлт тооцох;

32.1.3. ТШЗ-ны 30.1-д заасны дагуу тендерийн үнэд хийсэн арифметик алдааг залруулах;

32.1.4. ТШЗ-ны 29.1.1, 29.1.2, 29.1.3-т заасан үнийг шаардлагатай бол ТШЗ-ны 22.1-д заасан валютад хөрвүүлэх;

32.1.6. ТШЗ-ны 31.1-д заасан үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг мөнгөөр илэрхийлж тооцох.

32.2. ТШЗ-ны 1.2-т заасны дагуу хоёр ба түүнээс дээш багцтай тендер шалгаруулалтад хэд хэдэн багцад хамтад нь хамгийн бага харьцуулах үнэ санал болгосон тендерийг тодорхойлох, түүнд санал болгосон үнийн хөнгөлөлтийг тооцохдоо дараах аргачлалыг баримтална:

32.2.1. багц тус бүрийн хамгийн бага харьцуулах үнэтэй тендерийг сонгох;

32.2.2. хоёр ба түүнээс дээш багцад гэрээ байгуулах эрх авсан тохиолдолд үнийн хөнгөлөлт үзүүлэхээр санал болгосон тендерийн үнээс уг үнийн хөнгөлөлтийг тендер илгээх маягтад тодорхойлсон аргачлалын дагуу тооцсоны дараа шаардлагатай бол түүний харьцуулах үнийг дахин тодорхойлно. Ийнхүү тодорхойлохдоо хоёр ба түүнээс дээш багцад хамгийн бага харьцуулах үнэтэй тендер ирүүлсэн этгээд нь ТШЗ-ны 34-д зааснаар дахин магадлахад шаардлага хангаж байхыг шаардана;

32.2.3. дээрх үнэлгээг хийсний дараа тендерийн харьцуулах үнэд үндэслэн захиалагч гэрээ байгуулах эрхийг нэг багцад, хэд хэдэн багцад, эсхүл бүх багцад олгох хувилбаруудыг тооцож, гэрээний үнийн нийлбэр нь хамгийн бага байх хувилбарыг сонгох.

32.3. ТШЗ-ны 15.1-д зөвшөөрсний дагуу хувилбарт санал ирүүлсэн тендер “хамгийн сайн” гэж үнэлэгдсэн бол түүний хувилбарт саналыг хянан үзэж, үнэлнэ.

32.4. ТШЗ-ны 32.3-т зааснаар тендерийн саналын хувилбарыг хянан үзэх, үнэлэхэд үндсэн тендерийг үнэлсэн журмыг баримтална.

### **33. Тендерийг эрэмбэлэх**

33.1. Захиалагч тендерүүдийг эрэмбэлэхэд хуулийн 27.5, 27.6-д заасныг баримтална.

### **34. Оролцогчийн чадавхыг дахин магадлах**

34.1. Захиалагч хэд хэдэн багцад хамгийн сайн үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчийг тэдгээр багцад заасан гэрээний үүрэг гүйцэтгэх чадавхтай эсэхийг, мөн санал болгосон хүний нөөц, тоног төхөөрөмжийн мэдээлэл өөр бусад төсөл, арга хэмжээний мэдээлэлтэй давхацсан тохиолдолд дахин магадална.

## II БҮЛЭГ. ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

34.2. ТШЗ-ны 34.1-д заасны дагуу дахин магадлахад зөвхөн ТШЗ-ны 18.1-д заасан санхүүгийн чадавх, ТШЗ-ны 19.1-д заасан техникийн чадавх, туршлага, гэрээний үүрэг гүйцэтгэх чадавхын шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангах эсэхийг тендер хянан үзэхэд ашигласан баримт бичиг, мэдээлэлд үндэслэнэ.

34.3. Оролцогчийн чадавхыг дахин магадалж, хуулийн 27.10-т зааснаар гэрээ байгуулах эрх олгоно.

### Е. МЭДЭГДЭЛ ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ

**35.Мэдэгдэл хүргүүлэх** 35.1. Захиалагч хуулийн 28 дугаар зүйлд заасан шийдвэрийг хуулийн 24.1-д зааснаар ажлын 15 өдрийн дотор гаргаж, оролцогчдод мэдэгдэнэ.

**36.Гүйцэтгэлийн баталгаа** 36.1. Хуулийн 42.1-д заасан тохиолдолд гэрээ байгуулах эрх авсан оролцогч тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн гурван хувийн үнийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ.

36.2. Гүйцэтгэлийн баталгаа, урьдчилгаа төлбөрийн баталгааг “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-д нийцүүлэн гаргана.

**37.Урьдчилгаа төлбөр** 37.1. Гэрээг хэрэгжүүлж эхлүүлэхтэй холбогдох зардалд урьдчилгаа төлбөр олгохгүй.

**38.Гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах** 38.1. Захиалагч VI бүлгийн гэрээний нөхцөлийн гэрээ баталгаажуулах маягыг түүнд заасан зааврын дагуу шаардлагатай хэсгийг эцэслэн нөхөж, оролцогчид хүргүүлнэ.

38.2. Захиалагч тендер шалгаруулалтын үр дүнд нийлүүлэгчтэй гэрээ байгуулахад тендер шалгаруулалтын баримт бичгийн VI бүлэг дэх гэрээний нөхцөлийг баримтална.

38.3. Шалгарсан оролцогч ТШЗ-ны 38.1-д зааснаар ирүүлсэн гэрээнд гарын үсэг зурж, баталгаажуулан захиалагчаас шаардсан хугацааны дотор хүргүүлнэ.

38.4. Захиалагч хуулийн 30.4-т зааснаар ажлын 10 өдрийн дотор гэрээг баталгаажуулаагүй бол гэрээ байгуулах шийдвэрт заасан нөхцөлөөр гэрээ байгуулсанд тооцогдоно.

**39.Тендер гомдол шалгаруулалтын гомдол** 39.1. Хууль болон Сангийн сайдын баталсан “Тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх журам”-ын дагуу гомдлыг хянан шийдвэрлэнэ.

|                        |  |
|------------------------|--|
| ТШЗ-ны холбогдох заалт | <b>А. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ</b>   |
| ТШЗ 1.1                | Захиалагч: <i>Улаанбаатар хотын Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ</i>  |
| ТШЗ 1.1                | Тендер шалгаруулалтын нэр: <i>Зураг, төсөв хийх үйлчилгээ үзүүлэх.</i>   |
| ТШЗ 1.1                | Тендер шалгаруулалтын зарлалын дугаар: <i>УСУГ/20240103030/01/01</i>   |
| ТШЗ 1.2                | <p>Тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ:</p> <p><i>Багц№1: Чингэлтэйн ЦБ-ийн 0.4кВ цахилгаан хангамжийн ажлын зураг хийх</i></p> <p><i>Багц№2: ЛУБ-ийн агааржуулалтын системийн шинэчлэх ажлын зураг хийх үйлчилгээ үзүүлэх</i></p> <p><i>Багц№3: Бохир усны өргөх насос станцуудын нэг маягийн зураг төсөв хийх үйлчилгээ үзүүлэх</i></p> <p><i>Багц№4: Буянт-Ухаа 2 БУӨНС дулааны шугам татах зураг төсөв хийх үйлчилгээ үзүүлэх</i></p> <p><i>Багц№5: Яармагийн насос станцын гадна дулааны шугам шинээр татах зураг төсөв хийх үйлчилгээ үзүүлэх</i></p> <p><i>Багц№6: Тэхийн салбарын 7-р худгаас ф300 ширмэн шугамаар 24-р коллекторын 89-р худагт холбох ажлын зураг хийх үйлчилгээ үзүүлэх</i></p> <p><i>Багц№7: Маршаллийн гүүрэн доогуурх Их тэнгэрийн Ф100 ган шугамыг Ф150 хуванцар хоолой / HDPE / болгох ажлын зураг хийх үйлчилгээ үзүүлэх</i></p> <p><i>Багц№8: Чингисийн ф300 мм шугамыг Сэлбэ гол дундуур шулуутган шинэчлэх ажлын зураг төсөв хийх үйлчилгээ үзүүлэх</i></p> <p><i>Багц№9: Эрчим хүчний яамны салбар 7-р худгаас 12-р коллекторын 27-р худаг хүртэл шинэчлэх зураг төсөв хийх үйлчилгээ үзүүлэх</i></p> <p><i>Багц№10: ИНЕГ-н ф200 шугамыг Буянт-Ухаа 2 коллекторын ф500 шугамд холбох зураг төсөв хийх үйлчилгээ үзүүлэх</i></p> <p><i>Багц№11: Бохир усны өмнөдийн Ф1000мм коллекторын огцом эргэлтийг шулуун болгож шинэчлэх Ф1000мм ширмэн шугамаар холбох ажлын зураг төсөв хийх үйлчилгээ үзүүлэх</i></p> |
| ТШЗ 1.3                | Тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа эсэх: <i>“Үгүй”</i>   |
| ТШЗ 2.1                | Санхүүжилтийн эх үүсвэр нь: <i>Тухайн байгууллагын өөрийн хөрөнгө.</i>   |

|                          |  |
|--------------------------|--|
| ТШЗ 2.1                  | <p>Нийт төсөвт өртөг: <b>154,000,000.00</b> (нэг зуун тавин дөрвөн сая) төгрөг.</p> <p><b>Багц№1: 7,000,000.00</b> (долоон сая) төгрөг,</p> <p><b>Багц№2: 15,000,000.00</b> (арван таван сая) төгрөг,</p> <p><b>Багц№3: 24,500,000.00</b> (хорин дөрвөн сая таван зуун мянган)төгрөг,</p> <p><b>Багц№4: 15,000,000.00</b> (арван таван сая) төгрөг,</p> <p><b>Багц№5: 15,000,000.00</b> (арван таван сая) төгрөг,</p> <p><b>Багц№6: 11,000,000.00</b> (арван нэгэн сая) төгрөг,</p> <p><b>Багц№7: 5,000,000.00</b> (таван сая) төгрөг,</p> <p><b>Багц№8: 10,000,000.00</b> (арван сая) төгрөг,</p> <p><b>Багц№9: 11,000,000.00</b> (арван нэгэн сая) төгрөг,</p> <p><b>Багц№10: 9,000,000.00</b> (есөн сая) төгрөг,</p> <p><b>Багц№11: 31,500,000.00</b> (гучин нэгэн сая таван зуун мянган) төгрөг,</p> |
| <b>Б. АГУУЛГА</b>        |  |
| ТШЗ 9.1                  | <p>Тендерийн баримт бичгийн талаар тодруулга авах хаяг:</p> <p>Хүлээн авагчийн нэр: <b>Хангамжийн хэлтэс, Сонгон шалгаруулалт хариуцсан мэргэжилтэн С.Чинбаатар,</b></p> <p>Хаяг: <b>Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 3-р хороо, Ус Сувгийн Удирдах Газар, Токиогийн гудамж-5, өөрийн байр, 2 дугаар давхар 201 тоот.</b></p> <p>Утасны дугаар: <b>70157018-121.</b></p> <p>Цахим шуудангийн хаяг:</p>  |
| ТШЗ 10.1                 | Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт зохион байгуулах эсэх: <b>“Үгүй”</b>   |
| <b>В. ТЕНДЕР БЭЛТГЭХ</b> |  |
| ТШЗ 12.1                 | Тендер шалгаруулалтын хэл: <b>“Монгол хэл”</b>   |
| ТШЗ 15.1                 | Хувилбарт санал ирүүлэхийг: <b>“Зөвшөөрөхгүй”</b>  |
| ТШЗ 16.1.2               | <p>Ерөнхий шаардлагыг магадлахад шаардагдах бусад баримт бичиг: <b>“Шаардана”</b></p> <p><b>1. Монгол Улсын хуулийн дагуу татвар, даатгал, хураамж, төлбөрөө тухайн тендер нээсэн өдрийн байдлаар бүрэн төлсөн байна. Татварын, нийгмийн даатгалын, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын тодорхойлолтуудыг тендерт хавсарган ирүүлэх шаардлагагүй бөгөөд (цахим системээр ирүүлэх) худалдан авалтын цахим системээс өр, төлбөрийн талаарх мэдээллийг тендер нээсэн даруйд шалгах тул өр, төлбөргүй байх шаардлагатай.</b></p>  |

|                        |   |
|------------------------|---|
| <p><b>ТШЗ 18.1</b></p> | <p>Санхүүгийн чадавхын шаардлага: <b>“Шаардана”</b></p> <ol style="list-style-type: none"> <li><b>Борлуулалтын орлогын хэмжээ: 2023 онд борлуулалтын орлогын хэмжээ нь тухайн багцын төсвийн 100 хувиас дээш байх (мэдээллийг Сангийн яамны санхүүгийн тайлангийн <a href="http://www.e-balance.mof.gov.mn">www.e-balance.mof.gov.mn</a> мэдээллийн систем дэх санхүүгийн тайлангаас шалгана),</b></li> <li><b>2023 онд ашигтай ажилласан байх (мэдээллийг Сангийн яамны санхүүгийн тайлангийн <a href="http://www.e-balance.mof.gov.mn">www.e-balance.mof.gov.mn</a> мэдээллийн систем дэх санхүүгийн тайлангаас шалгана),</b></li> <li><b>Монгол Улсын хуулийн этгээдийн банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх талаар Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан этгээдийн лавлагаа ирүүлэх.</b></li> <li><b>Банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өргүй байна. (Харилцагч банкны тодорхойлолтыг тендерийг үнэлэхэд харгалзан үзэхгүй.)</b></li> </ol>  |
| <p><b>ТШЗ 18.2</b></p> | <p>Санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох баримт бичиг:</p> <ol style="list-style-type: none"> <li><b>Оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох санхүүгийн тайлангийн хугацаа: 2023 он,</b></li> <li><b>Сангийн яамны санхүүгийн тайлангийн <a href="http://www.e-balance.mof.gov.mn">www.e-balance.mof.gov.mn</a> мэдээллийн систем дэх санхүүгийн тайлангаас шалгана,</b></li> </ol>   |
| <p><b>ТШЗ 19.1</b></p> | <p>Техникийн чадавх болон туршлагын шаардлага: <b>“Шаардана”</b></p> <p>Үйлчилгээ үзүүлэх хүний нөөц: <b>“Шаардана”</b></p> <ol style="list-style-type: none"> <li><b>Үйлчилгээг үзүүлэх ажилчдын мэдээллийг V-р бүлгийн маягт 7,10-н дагуу ирүүлэх.</b></li> </ol> <p>Үйлчилгээ үзүүлэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл: <b>Шаардахгүй”</b></p> <p>Ижил төстэй үйлчилгээ үзүүлсэн туршлага: <b>“Шаардана”</b></p> <ol style="list-style-type: none"> <li><b>2022, 2023 оны аль нэг жилд ижил төстэй үйлчилгээ үзүүлсэн тухай мэдээлэл ирүүлэх (гэрээний хуулбар, ажил хүлээлцсэн акт эсвэл гэрээ дүгнэсэн протокол хуулбар, тухайн гэрээний үнийн дүн бүхий и-баримтын <b>“илгээгдсэн”</b> төлбөрийн баримтын хуулбарыг ирүүлэх, <b>“нэхэмжлэх”-ийн хуулбар ирүүлэхийг тооцохгүйг анхаарна уу!</b></b></li> </ol> <p>Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх шаардлага: <b>“Шаардана”</b></p> <p>Техникийн чадавх болон туршлагын шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангахыг нотлох бусад шаардлага: <b>“Шаардана”</b>.</p> <ol style="list-style-type: none"> <li><b>Гэрээний үүргийн гүйцэтгэлийг хариуцах ажилтны нэр, боловсрол, мэргэжлийн ур чадварын мэдээлэл.</b></li> <li><b>V-р бүлгийн маягт 6-н дагуу тухайн үйлчилгээг хийж гүйцэтгэх хуваарь ирүүлэх.</b></li> </ol> |

|                        |   |
|------------------------|---|
|                        | <ol style="list-style-type: none"> <li>5. <i>V-р бүлгийн маягт 5-н дагуу үйлчилгээг үзүүлэх ажлын хөтөлбөр болон аргачлалын талаарх танилцуулга бэлтгэн ирүүлэх.</i></li> <li>6. <i>Гүйцэтгэгч байгууллага нь гэрээт ажил дээр ажиллах ажилчдын хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйг бүрэн хариуцаж ажиллах, хүн нэг бүрийг хамгаалах хэрэгслээр хангаж ажиллах тухайгаа албан бичгээр ирүүлэх.</i></li> <li>7. <i>Тендерт оролцогч нь манай байгууллагын шийдвэр гаргах түвшиний албан тушаалтан, инженер техникийн ажилтануудтай нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхолыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3.1.5, 3.1.6, 11.1-д заасан нөхцөл байдал үүсээгүй болохыг илэрхийлсэн албан бичиг ирүүлэх. Хэрэв дээрх нөхцөл байдал үүссэн тохиолдолд тухайн тендерээс татгалзах үндэслэл болно. /Дээрх нөхцөл үүссэнийг нуун дарагдуулсан болон худал мэдүүлснээс гарах үр дагаврыг үнэлгээний хороо нь хариуцахгүй болно/</i></li> <li>8. <i>Тендерийн баримт бичиг нь үнэн зөв, тодорхой гаргацтай байна. Унших боломжгүй, тодорхойгүйн улмаас үнэлгээ хийх боломжгүй нөхцөл байдал үүсэхээр бол үнэлгээний хороо нь уг тендерээс татгалзах үндэслэл болно.</i></li> <li>9. <i>Дээр заасан материалуудын аль нэгийг ирүүлээгүй тохиолдолд уг тендерээс татгалзах үндэслэл болно.</i></li> </ol> |
| <p><b>ТШЗ 19.2</b></p> | <p>Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг нотлох баримт бичиг:</p> <ul style="list-style-type: none"> <li>- <i>19.1.1-д Хүний нөөцийг мэдээллийг V бүлгийн маягтын дагуу ирүүлэх санал болгож буй ажилчид нь тухайн байгууллагын үндсэн ажилтан байх шаардлагатай. Тухайн тендерийн нээлт хийхээс өмнөх 3 сарын нийгмийн даатгал төлөлт болон дотоодын их, дээд сургуулийн мэргэжлийн дипломын талаарх мэдээллийг ирүүлэх шаардлагагүй ба худалдан авах ажиллагааны цахим системээс шалгах болно(ажилчдын регистрийн дугаарыг ирүүлэх). Жич: гадаад сургууль болон бусад диплом, гэрчилгээний хуулбарыг тендертэй хамт ирүүлэх.</i></li> <li>- <i>Сүүлийн жил буюу 2023 онд ижил төстэй үйлчилгээ үзүүлж байсан талаарх гэрээний мэдээллийг V бүлгийн Маягт 2, Маягт 3-ын дагуу ирүүлэх.</i></li> <li>- <i>Сүүлийн 3 жил манай байгууллагад ямар нэгэн бараа, ажил, үйлчилгээ үзүүлж байсан бол тухайн ажлын чанар, гүйцэтгэл (бараа, ажил, үйлчилгээг хүлээлцсэн акт, гэрээ дүгнэсэн протокол)-ийг сонгон шалгаруулалтын үнэлгээнд харгалзан үзнэ.</i></li> </ul>   |
| <p><b>ТШЗ 19.3</b></p> | <p>Тусгай зөвшөөрөл/зөвшөөрөл: <b>“Шаардана”</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- <i>Багц №1 дээр Зураг төслийн ТЗ-8.4 тусгай зөвшөөрөлтэй байх.</i></li> <li>- <i>Багц №2 дээр Зураг төслийн ЗТ-6.2 тусгай зөвшөөрөлтэй байх.</i></li> <li>- <i>Багц №4,5 дээр Зураг төслийн ЗТ-3.5, ЗТ-4.5-н аль нэг тусгай зөвшөөрөлтэй байх.</i></li> <li>- <i>Багц №3,6,7,8,9,10,11 дээр Зураг төслийн 1.3.1 эсвэл ЗТ-3.4, ЗТ-4.4-н аль нэг тусгай зөвшөөрөлтэй байх.</i></li> </ul>   |

|   |  |
|---|--|
| ТШЗ 21.4                                      | Оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад:<br><b>“Тохируулахгүй тогтмол байна”</b>  |
| ТШЗ 24.1                                      | Тендерийн баталгааны дүн: <b>“Шаардахгүй”</b>  |
| <b>Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ</b>                 |  |
| ТШЗ 25.5                                      | Оролцогчдод ил болох баримт бичгийн жагсаалт:<br><ol style="list-style-type: none"> <li>1. <b>V-р бүлгийн маягт 6-н дагуу тухайн үйлчилгээг хийж гүйцэтгэх хуваарь ирүүлэх.</b></li> <li>2. <b>Багц №1 Тусгай зөвшөөрөл.</b></li> </ol>  |
| ТШЗ 26.1                                      | Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь:<br>Огноо: <b>2024 оны 05 дугаар сарын 16-ний өдөр.</b><br>Цаг: <b>09 цаг 00 минут.</b>   |
| ТШЗ 26.2                                      | Тендерийн нээлтийг доор дурдсан хугацаанд цахим системээр хийх бөгөөд нээлтийн мэдээллийг оролцогч цахим системээр хүлээн авна.<br>Огноо: <b>2024 оны 05 дугаар сарын 16-ний өдөр.</b><br>Цаг: <b>09 цаг 30 минут.</b><br>Тендер нээлтэд оролцох боломжтой газрын хаяг: <b>Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 3-р хороо, Ус Сувгийн Удирдах Газар, Токиогийн гудамж-5, өөрийн байр, 2 дугаар давхар 201 тоот.</b> |
| <b>Д. ТЕНДЕРИЙГ ХЯНАН ҮЗЭХ, ҮНЭЛЭХ</b>        |  |
| ТШЗ 31.1                                      | Тендер үнэлэх үндсэн шалгуурыг харьцуулах үнээс өөрөөр тогтоох эсэх:<br><b>“Үгүй”</b>  |
| <b>Е. МЭДЭГДЭЛ ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ</b> |  |
| ТШЗ 36.1                                      | Шалгарсан оролцогч гүйцэтгэлийн баталгаа ирүүлэх эсэх: <b>“Үгүй”</b>   |



### III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

Багц№1: Чингэлтэйн ЦБ-ийн 0.4кВ цахилгаан хангамжийн ажлын зураг хийх

БАТЛАВ  
УС СУВГИЙН УДИРДАХ ГАЗРЫН ЕРӨНХИЙ  
ИНЖЕНЕР *М. Дарваасүрэн* ДАГВАСҮРЭН

2024 оны 02 дугаар сарын 16

ТТБ2578.а.7117208

УЛААНБААТАР ХОТЫН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН НУТАГ ДЭВСГЭРТ БАЙРЛАХ УС  
СУВГИЙН УДИРДАХ ГАЗРЫН ХАРЬЯА ЧИНГЭЛТЭЙН ЦЭВЭРЛЭХ БАЙГУУЛАМЖИЙГ  
ТӨВЛӨРСӨН ЦАХИЛГААН СҮЛЖЭЭТЭЙ ХОЛБОХ АЖЛЫН ЗУРГИЙН ДААЛГАВАР

Дугаар 01/2024

2024 оны 02 дүгээр сарын 14

Улаанбаатар хот

|    |   |  |
|----|---|--|
| 1  | Зураг төсөл боловсруулах үндэслэл           | УБЦТС ТӨХК-ийн 2024 оны 02 дугаар сарын 09-ний өдөр олгогдсон № 01/00205/24 дугаартай техникийн нөхцөл   |
| 2  | Байршил                                     | Улаанбаатар хот Чингэлтэй дүүрэг 20-р хороо хувьсгалчдын гудамж 12-138 тоот, Чингэлтэйн цэвэрлэх байгууламж  |
| 3  | Зураг төсөл боловсруулахад ашиглах материал | 1. Монгол улсын Барилгын тухай хууль<br>2. "Гадна цахилгаан хангамж" БНБД23-02-08<br>3. Үйлдвэрлэлийн барилгын норм БНБД31-11-09<br>4. Бусад холбогдох норм дүрмүүд  |
| 4  | Төлөвлөлтөнд тавигдах шаардлага             | 1. Техникийн нөхцлийн дагуу шинээр суурилуулах тоноглолууд нь батлагдсан норм стандартыг хангасан сүүлийн үеийн дэвшилтэт техник, технологи байх.<br>2. Ажлын зураг төсөл боловсруулах явцад ашиглагч, захиалагч болон бусад холбогдох байгууллагатай зөвшилцсөн байх. (УБЦТС ТӨХК, ОНӨААТҮГ, МХС ТӨХК болон бусад)<br>3. Ажлын зураг төсвийг эрх бүхий байгууллагаар магадлал хийлгэж баталгаажуулсан байх. |
| 5  | Зураг төслийн иж бүрдэл                     | 1. Мэргэжлийн байгууллагын Геодези, хөрсний усны дүгнэлт.<br>2. Цахилгаан хангамж, шугам сүлжээний угсралтын батлагдсан, магадлал хийгдсэн ажлын зураг төсөл, бичиг баримт, график зураглал CD-ний хамт.<br>3. Ажлын зургийг үндэслэн хийгдсэн хяналтын төсөв.   |
| 6  | Зураг төсөл боловсруулах үе шат             | 1 үе шаттай.   |
| 7  | Зураг төсөл боловсруулж дуусах хугацаа      | Гэрээнд заасан хугацаанд хийнэ.  |
| 8  | Зураг төслийн байгууллага                   | Сонгон шалгаруулалтаар сонгох  |
| 9  | Зураг төсөл захиалагч байгууллага           | Ус сувгийн удирдах газар   |
| 10 | Зураг төслийн санхүүжилт                    | Ус сувгийн удирдах газрын санхүүжилтээр  |
| 11 | Онцгой нөхцөл                               | 1. Цахилгаан хангамжийн зураг төсөвт тухайн цэвэрлэх байгууламжийн цахилгаан хүчдэл тасарсан үед автоматаар залгагдан ажиллах суурилагдсан чадалд тохирох генератор буюу цахилгаан үүсгүүр төлөвлөх.<br>2. УБЦТС ТӨХК-ийн 2024 оны 02 дугаар сарын 09-ний өдөр олгогдсон №01/00205/24 дугаартай техникийн нөхцөлд тусгагдсан өгөгдөл тусгай заалтуудыг зураг төсөвт тусгах.                                  |

|    |                              |  |
|----|------------------------------|--|
| 12 | Галын аюулгүй байдлын нөхцөл | Галын аюулгүйн норм БНБД21-02-02   |
| 13 | Эдийн засгийн тооцоо төсөв   | Төсвийг ESTIMATOR PRO болон бусад зохих эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн программаар БНБД81-85-12*/2020/-ыг баримтлан тооцох |

ЗӨВШӨӨРСӨН:

ИНЖЕНЕРИЙН БОДЛОГЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА

Н.ОДХҮҮ

БОЛОВСРУУЛСАН:

ЦБА-НЫ ДАРГА

ИБХ-ИЙН ИНЖЕНЕР

ЦБА-НЫ АХЛАХ ИНЖЕНЕР

ЦБА-НЫ ЦАХИЛГААНЫ ИНЖЕНЕР

О.ОЮУНБАЯР

Ж.БАТЖАРГАЛ

Б.БАДАМХАНД

Ц.ОТГОНСҮРЭН



ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ

Дугаар 01/00205/24

2024 оны 2 сарын 9 өдөр

Улаанбаатар хот

Нэг. Ерөнхий мэдээлэл

|     |                                     |  |
|-----|-------------------------------------|--|
| 1.1 | Хүсэлтийн дугаар                    | 240200053  |
| 1.2 | Хэрэглэгчийн нэр,<br>регистр:       | УС СУВГИЙН УДИРДАХ ГАЗАР, РД:2117568   |
| 1.3 | Хэрэглэгчийн байршил:               | ЧД 7-р хороо Хувьсгалчдын Г-12, 138 тоот   |
| 1.4 | Ажил үйлчилгээний<br>зориулалт:     | Инженерийн байгууламж  |
| 1.5 | Техникийн нөхцөл<br>олгох үндэслэл: | 1.5.1) 2024-02-01-ний өдрийн УСУГ-ын 2/182 тоот<br>албан бичиг<br>1.5.2) Газар эзэмших эрхийн 2023-07-17-ны нэгж<br>талбарын 1500811034 дугаартай гэрчилгээ<br>1.5.3) Өмнө нь авсан 2020 оны 05 сарын 10-ны өдрийн<br>15/01705/20 тоот техникийн нөхцөл. |
| 1.6 | Техникийн нөхцөлийн<br>ангилал:     | Шинэ холболт   |
| 1.7 | Суурилагдсан хүчин<br>чадал         | 30 кВА (Гучин кВА)   |
| 1.8 | Хүчдэлийн түвшин                    | 380В   |

Хоёр. Холболтын цэг

|     |  |
|-----|--|
| 2.1 | 110/35/10 кВ-ын Телевиз дэд станцын 10 кВ-ын "Дэд төв А.Б" фидерийн ХТП-5841 дэд өртөөний 0.4 кВ талын I ба II секцэд шинээр рубильник бүхий групп тоноглож кабель шугам татаж тэжээх. |
|-----|--|

Гурав. Тоолуур, хэмжих хэрэгсэл:

|     |   |
|-----|---|
| 3.1 | Монгол Улсын Засгийн газрын тохируулагч агентлаг-Стандарт, хэмжилзүйн газрын загварын туршилт орон, ашиглахыг зөвшөөрч, баталгаажуулсан байх.   |
| 3.2 | 0.4 кВ-ын щитэнд 50 А-ийн дифференциал автомат болон хамгаалан таслах төхөөрөмж /УЗО/ суурилуулах, УБЦТС ТӨХК-д ашиглагдаж байгаа ухаалаг тоолуурын системд холбогдон ажилладаг, DLMS протоколыг дэмждэг, 4G модемтой, чадал хязгаарлах функцтай, алсаас таслах залгах зориулалттай, 3 фазын 100 А-ийн ухаалаг тоолуур суурилуулах. |

Дөрөв. Тусгай заалтууд:

- 4.1 Дэд ертөө, щитний газардуулга болон шугам тоноглолын хэмжилт, туршилтыг норм, дүрмийн дагуу хийлгэн холбогдох газраар шалгуулж протокол авсан байх.
- 4.2 Энэхүү техникийн нөхцөл нь дараах нөхцөл, шаардлагуудыг хангасан тохиолдолд хүчинтэй болно.
- 4.2.1) Энэхүү техникийн нөхцөлийн хүчинтэй байх хугацаанд түгээх сүлжээнд холбогдсон байх шаардлагатай.
- 4.2.2) Эх үүсвэр дэд станц, шугам тоноглол хэт ачаалагдсан тул түгээх сүлжээнд 2024, 2025 онд цахилгаан ачаалал нэмэх боломжгүй. Шугам сүлжээнээс 2026 онд 10 кВА чадлаас хэтрэхгүйгээр хангана.
- 4.2.3) Цаашид эх үүсвэр дэд станц, шугам тоноглолын хүчин чадлыг нэмэгдүүлж өргөтгөл шинэчлэлийн ажил хийгдсэний дараа олгосон бүрэн чадлыг үе шаттайгаар ашиглах боломжтой юм.
- 4.3 Гадны эзэмшлийн шугам тоноглолоос холбогдох тохиолдолд зураг төсөл боловсруулах шатанд эзэмшигчээс зөвшөөрөл авч, зөвшилцсөн байх.
- 4.4 Шугам тоноглолын гүйцэтгэлийн зургийг гаргаж, ашиглагч байгууллага УБЦТС ТӨХК-д хүлээлгэн өгөх, гүйцэтгэлийн зургийг гаргахдаа кабель шугамын холболтын муфтуудыг заасан, бусад инженерийн шугам сүлжээ, авто замтай огтлолцсон хэсгийн зүсэлтийг тусгах.
- 4.5 Цахилгаан дамжуулах шугамын трассыг одоо байгаа болон ойрын хугацаанд баригдахаар төлөвлөгдсөн бусад шугамын гаргалгаа, трасстай аль болох огтлолцохгүй байхаар төлөвлөн, зураг төслийн шатанд бусад инженерийн байгууламж хариуцсан байгууллагуудтай зөвшилцөн сонгох.
- 4.6 Барилга угсралтын ажлын зураг нь ЦБД, ТАД, ААД, ЭХ-ний шугам сүлжээг хамгаалах дүрэм, ЭХ хэрэглэх дүрэм болон УБЦТС ТӨХК-аас хэрэгжүүлж байгаа ашиглалт борлуулалтын арга хэмжээний шаардлагуудыг хангасан байна.
- 4.7 Галын хор, щит, самбар, пунктыг галын аюулгүйн дүрэмд заагдсаны дагуу байрлуулж, галын аюулгүй байдлыг хангах.
- 4.8 Түгээх сүлжээний үндсэн шугам нь хэт урт, ачаалал ихтэйгээс шалтгаалан хэрэглэгчид очих эрчим хүчний чанар, стандартын шаардлага хангахгүй тохиолдолд хүчдэл өргөх төхөөрөмж сууриулах болон техникийн нэмэлт арга хэмжээнүүдийг УБЦТС ТӨХК-тай хамтарсан хэмжилт туршилтын үндсэн дээр хэрэгжүүлнэ. Нэмэлт ажилтай холбоотой гарах зардлыг хэрэглэгч бүрэн хариуцна.
- 4.9 Техникийн нөхцөлийн дагуу шинээр суурилуулах тоноглолууд нь өмнө ашиглагдаж байгаагүй шинэ байх, кабель шугам, трансформаторууд нь сүүлийн үеийн байгаль орчинд ээлтэй, дэвшилтэд техник технологи бүхий байх. Нэгдсэн сүлжээний дүрэмд заасны дагуу  $\pm 10\%$ -ийн хүчдлийн хэлбэлзэлд хэвийн ажиллах.
- 4.10 УБЦТС ТӨХК-ийн эзэмшлийн шугам дэд станцад хийгдэх өргөтгөлийн ажлыг харьяа түгээх төвөөр гүйцэтгүүлэх.
- 4.11 Өөрийн дэд станц, шугам тоноглолоос хангагчийн зөвшөөрөлгүйгээр бусад хэрэглэгчийг холбосон тохиолдолд цахилгаан хангамж, хэрэглээг түдгэлзүүлнэ.
- 4.12 Энэхүү техникийн нөхцөл батлагдсантай холбоотойгоор өмнө нь авсан 2020 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 15/01705/20 тоот техникийн нөхцөлийг хүчингүйд тооцно.
- 4.13 Барилгын талбайд орсон УБЦТС ТӨХК-ийн эзэмшлийн бус тоноглолын талаар эзэмшигчээс зөвшөөрөл авах.
- 4.14 Шинээр баригдах цахилгаан дамжуулах кабель шугам нь:
- 4.14.1) Шинээр татах кабель шугамын хөндлөн огтлолыг хэрэглээ ачаалалтай

|      |  |
|------|--|
|      | уялдуулан зураг төслийн шатанд тооцоогоор сонгох.  |
|      | 4.14.2) Цахилгаан дамжуулах кабель шугам нь 1 кВ-ын хүчдлийн түвшинд ашиглах, орчны температур -15 хэм байхад угсралт хийх боломжтой байх.   |
| 4.15 | Өвлийн их ачааллын улиралд эрчим хүчний системийн горим ажиллагааг хангах үүднээс урьдчилан мэдэгдэлгүйгээр хязгаарлалт хийж болзошгүй тул нөөц эх үүсгүүрийг бэлэн байдлыг хангаж ажиллахыг анхаарна уу.  |
| 4.16 | Өвлийн их ачааллын горимд тус цахилгаан ачааллыг залгах боломжгүй тул жил бүрийн 11-р сарын 01-ээс 03-р сарын 01 хүртэл ахуйн хэрэглээнээс бусад цахилгаан ачааллыг нэгдсэн системийн зохицуулалтаар хязгаарлах арга хэмжээ авах нөхцөлөөр энэхүү техникийн нөхцөлийг олгов. |
| 4.17 | Цахилгаан эрчим хүчний өвлийн их ачааллын улирал эхэлж байгаатай холбогдуулан энэхүү техникийн нөхцөлийн дагуу 2024 оны 03 сарын 01-нээс хойш сүлжээнд холбогдохыг анхаарна уу.  |

**Тав. Дор дурдсан техникийн даалгавар, хууль дүрмийг мөрдөх:**

|      |   |
|------|---|
| 5.1  | Шугам, дэд өртөөний "Ажлын зураг төсөл"-ийг ЦБД, ТАД, ААД, ГАБХД, ЭХ-ний шугам сүлжээг хамгаалах дүрэм, Эрчим хүч хэрэглэх дүрмийн дагуу хийж гүйцэтгэх бөгөөд тухайн нутаг дэвсгэрийн ерөнхий төлөвлөгөө хариуцсан нэгж болон бусад шаардлагатай байгууллагуудтай зөвшилцөж, мэдээллийн санд оруулсан байх, схем холболт, хүчин чадлыг тус компаниар хянуулах.     |
| 5.2  | Энэхүү техникийн нөхцөлийн дагуу тавигдах шугам, тоноглолууд нь Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ төрийн өмчит хувьцаат компанийн баталсан "Техникийн шаардлагын тодорхойлолт"-ыг хангасан байх шаардлагатай. Техникийн шаардлагын тодорхойлолтыг <a href="http://www.tog.mn">www.tog.mn</a> хаягаар орж хууль, эрх зүйн акт хавтасны баримт бичиг цонхноос үзэх. |
| 5.3  | Хүсэлт гаргагч нь хэрэглэх чадалдаа тохируулж чадлын хязгаарлагч, богино залгааны гэмтэл заагч датчикийг суурилуулах. Техникийн шаардлагын тодорхойлолтыг <a href="http://www.tog.mn">www.tog.mn</a> хаягаар орж хууль, эрх зүйн акт хавтасны баримт бичиг цонхноос үзэх.   |
| 5.4  | Цахилгаан шугам сүлжээнд холбогдох явцад дайрч гарах зам талбай, бут сөөгийг сэргээн засварлах.   |
| 5.5  | "Эрчим хүчний тухай хууль"-ийн 30.1.13-д заасны дагуу нийтийн эзэмшлийн орон сууцны барилга барьж байгаа учир шинээр барьсан эрчим хүчний дэд станц, шугам, тоноглолыг тусгай зөвшөөрөл эзэмшигчид шилжүүлэх.   |
| 5.6  | Засгийн газрын 2020 оны 97 тоот тогтоолоор батлагдсан "Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм"-ийн заалтуудыг мөрдлөг болгох.   |
| 5.7  | "Эрчим хүчний тухай" хуулийн 29.1.9 -д заасны дагуу хангагч нь хэрэглэгчийн өмчлөлийн шугам дэд станцаас нутаг дэвсгэрийн хэтийн төлөвийн үндсэн дээр өөр бусад хэрэглэгчийг нэмж холбох эрхтэй.  |
| 5.8  | "Эрчим хүчний тухай хууль"-ийн 30.1.8-д заасны дагуу өөрийн эзэмшлийн шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн, аюулгүй байдал, засвар үйлчилгээ, баталгаажуулалтыг бүрэн хариуцах ба харьяа түгээх төв болон бусад тусгай зөвшөөрөл эзэмшигчидтэй ашиглалт үйлчилгээний гэрээ байгуулах.   |
| 5.9  | Түгээх сүлжээнд залгагдах болон залгаатай байгаа хувийн шугам тоноглол эзэмшигч нь өөрийн шугамын урт, тоноглолын хүчин чадлаас хамааруулан тус компанийн харьяа түгээх төвтэй шуурхай ажиллагааны гэрээг байгуулах.  |
| 5.10 | Хэрэглэгч нь техникийн нөхцөлийн дагуу захиалсан чадлаа бүрэн ашиглаж чадаагүй нь цахилгаан эрчим хүчний хэрэглээгээр нотлогдсон бол олгогдсон чадлын хэмжээг бууруулж дахин техникийн нөхцөл олгоно.   |

- |      |  |
|------|--|
| 5.11 | “Эрчим хүчний тухай” хуулийн 33 дугаар зүйлд заасны дагуу шугам сүлжээний хамгаалалтын зурвас дотор гэр, орон сууц, барилга байгууламж барих, шугам сүлжээ өмчлөгч, эзэмшигчийн зөвшөөрснөөс бусад үйл ажиллагаа явуулахыг хориглоно.  |
